

Оролцоог хангаж байгаль орчноо өөрчлөх нь

Оролцоог хангасан хамтын ажиллагаа

Байгаль орчинд хэрхэн нөлөөлдөг тухай



Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Эдийн засаг - Нийгмийн комисс нь НҮБ-ийн бүсийн хөгжлийн удирдлагыг хангахын сацуу энэ бүс нутаг дахь НҮБ-ийн эдийн засаг болон нийгмийн хөгжлийн үндсэн төвийн үүргийг гүйцэтгэдэг. Энэхүү комисс нь өөрийн 53 гишүүн болон есөн хамтрагч гишүүдийн хамтын ажиллагааг дэмжих үүрэгтэй. Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Эдийн засаг - Нийгмийн комисс (ЭСКАП) нь дэлхийн болон улс орны төвшний хөтөлбөр болон асуудлуудын хоорондын стратегийн уялдааг хангах, засгийн газруудад бүсийн хэмжээний байр суурийг нэгтгэхэд дэмжлэг үзүүлэх, даяарчлагдаж буй дэлхийн хэмжээнд бий болж буй нийгэм-эдийн засгийн онцгой асуудлуудыг хангах бүсийн хандлага, арга замуудын талаар зөвлөмж зөвлөгөө өгдөг. ЭСКАП-ын төв нь Бангкок хотод байрладаг.

Оролцоог хангах замаар Уул уурхайн салбар дахь байгаль орчны зохицуулалтыг сайжруулах нь, Улаанбаатар хот, Монгол улс

Сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол улсын уул уурхайн салбар огцом хүрээгээ тэлж орон нутгийн ард иргэд болон малчдын амьдралд нөлөөлж буй байгаль орчны болон нийгмийн үр дагаврыг дагуулж буй. Газар нутгийн нөхөн сэргээлтийг судлах явцдаа Монгол улсын Хүний Эрх Хөгжил Төв (ХЭХТ) байгаль орчинд учирч буй хор хохирлыг үнэлэх заавар зөвлөмж байдаггүйг олж мэдсэн билээ. ХЭХТ 2005 оноос эхлэн уул уурхайн салбартай холбоотойгоор олон нийтийн эрх ашгийн стратегийн хамгааллыг хийж эхэлсэн бөгөөд уул уурхайн лицензийн үйл явц, Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээ болон газар нутгийн нөхөн сэргээлт гэсэн асуудлууд дээр голчлон ажилласан.

ХЭХТ баримт цуглуулах судалгаа хийх, сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулан хэвлэх зэргээр уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн засаг захиргаа, хуульчид, орон нутгийн ард иргэдтэй хамтран ажилладаг. Олон нийтэд мэдээлэл хүргэх, үр чадварыг сайжруулах үйл ажиллагаа нь олон улсын болон улсын стандартуудад тусгалаа олж хүчин төгөлдөр байгаа хууль журмуудад тусгагдаагүй асуудлуудыг тодорхойлж өгсөн билээ. Энэ бүх үйл ажиллагаа нь уул уурхайн нөлөөлөлд өртсөн нутгийн ард иргэдэд дэмжлэг туслалцаа болсон төдийгүй шударга ёс, хариуцлагыг хөхүүлэн дэмжсэн олон нийтийн эрх ашгийг хамгаалан стратегийн өмгөөлөл болж байгаа юм. Хүний Эрх, Хөгжлийн төлөөх Азийн Форум (ФОРУМ-АЗИ) Азийн бүсийн байгаль орчин болон хүний эрхийн байгууллагуудыг ХЭХТ-тэй холбон хамтын ажиллагааг хангах замаар ХЭХТ-ийн санал санаачлагуудыг дэмжиж ирсэн төдийгүй улсын болон олон улсын төвшинд үр чадвар хөгжүүлэх, хамтын өмгөөллийн үйл ажиллагааг хангасан юм.

ХЭХТ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийхэд олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг албажуулах ажлыг хариуцан ажилласан. Олон нийтийн эрх ашгийг өмгөөлөх нь өмгөөллийн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн засаг захиргаа болон ард иргэдийг эрх мэдэлжүүлэх, эрхзүйн талаарх тэдний мэдлэг мэдээллийг өргөжүүлж буй юм. Байгаль Орчны Яам 2014 оны 1-р сарын 6-ны өдөр энэхүү зохицуулалт журмыг баталжээ. ХЭХТ 2015 оноос эхлэн Дорнод аймгийн зарим газар нутгийг тусгай хамгаалалттай болгохын тулд Засгийн газар болон УИХ-ын төвшинд лобби ажиллагаа явуулах, өмгөөлөл хийх, 3023 иргэнээс гарын үсэг цуглуулах зэргээр аймгийн захиргаанд дэмжлэг үзүүлж ирсэн болно. 2019 оны 5-р сард УИХ-ын тогтоолоор Дорнод аймгийн зургаан сумын есөн газар нутгийг тусгай хамгаалалттай болгосон юм.



Хүний Эрх, Хөгжлийн төлөөх Азийн Форум (Форум-Ази) <https://www.forum-asia.org/uploads/wp/2018/03/FORUM-ASIA-Working-Paper-Series-No.-3-Online.pdf>
<http://mongolia.panda.org/en/?uNewsID=346744#>

